


ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ НОГООН ХӨГЖИЛ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХЭРЭГЖИЛТ

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

1. 2021-2023 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал, орон нутгийн төсөв болон хувийн хэвшлийн хөрөнгөөр 18 суманд нийт 80 булаг, шанд, рашааны эхийг хашиж хамгаалан нутгийн иргэдэд хариуцуулсан.



-2023 онд Байгаль орчин, аялал жуулчлалын газраас 15 булаг шандны эх хашиж хамгаалах материал нийлүүлэх гэрээг байгуулж, сумдад байаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Хужирт 10, Арвайхээр-1, Зүүнбаян-Улаан 1, Гучин-Ус 2, Уянга 3, нийт 18 булаг хашиж хамгаалан Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг бууруулах үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн манлайлал төслөөс Арвайхээр сумын Бурхийн эхийг хашиж хамгааллаа.

-Нарийнтээл сумын Их булаг хэмээх газарт хөв цөөрөм байгуулах ажлын зураг төслийг 2022 онд усны мэргэжлийн байгууллага “Гидрофонтан” ХХКомпаниар гүйцэтгүүлж, 2023 онд тус зураг төслийн дагуу хөв цөөрөм байгуулах ажлыг “Усны барилга” ХХК улсын төсвийн 335.220.690, “Баянтээг” ХК нийгмийн хариуцлагын хүрээнд 56.0 сая нийт 391.220.690 төгрөгний санхүүжилтээр гүйцэтгэж улсын комист хүлээлгэн өгсөн.

2. Дэлгэрэх голын голдрилын төгсгөл хэсэг болох 820.0 м газарт голын голдрилыг шулуутгах ажлыг 2021 онд “Өндөр Сант хайрхан” ХХК хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Тус ажлын хүрээнд үерээс хамгаалах далан, бетонон доторлогоо, 2 ш үерийн хоолой, бэхэлгээний шүд зэрэг барилга байгууламжийг зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн. Дээрх газарт ногоон байгууламж нэмэгдүүлэх зорилгоор 1000 м газарт хамгаалалтын хашаа барьж, 3 ш сүүдрэвч байгуулж, 12000 гаруй мод бут, сөөгийг 2,4 га талбайд тарьсан.

-2023 онд Дэлгэрэх голын голдирол үерийн усны нөлөөгөөр эвдэрч гэмтэхээс хамгаалах үүднээс хөвийн дарагдсан лаг хагшаасыг цэвэрлэж, инженерийн байгууламж, суваг хоолойг хэвийн үйл ажиллагаанд оруулах ажлыг Арвайхээр сумын ЗДТГ, Онги-Таац голын сав газрын захиргаа хамтран зохион байгуулж, ажлын гүйцэтгэгчээр “Арвайхээр тохижилт, үйлчилгээ” ОНӨААТҮГ ажиллаж 10,0 сая төгрөгийн санхүүжилтээр хийж гүйцэтгэсэн ба нийт 2360м3 лагийг ачиж, зөөж тээвэрлэн Арвайхээр сумын хог хаягдлын нэгдсэн цэгт хүргэж, хог хаягдлыг дарж булшлан, 800м2 газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн.

3. Хужирт сумын төвийн хүн амын усан хангамжийн эх үүсвэрийн нөөцийг үнэлэх судалгааны ажлыг “Карст” ХХКомпани гүйцэтгэн сумын төвийн хүн амын усан хангамжийн эх үүсвэрийн нөөцийг үйлдвэрлэлийн В зэргээр 18.0 л/с буюу 1555.2 м3/хоногоор, Хайрхандулаан сумын хүн амын ундны усны нөөцийг тогтоох ажлыг тусгай зөвшөөрөл бүхий “Цагаан зуун” ХХКомпаны туслан гүйцэтгэгч Баян Заг ХХК гүйцэтгэн сумын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг 4,8 л/секундээр тус тус тогтоогдсон.

4. Орон нутгийн чанартай бүрэн судлагдаагүй Бат-Өлзий сумын Хуст, Ар хятруун, Могойт, Үүртийн тохой, Баруунбаян-Улаан сумын Хүрэн хад, Уянга сумын Өвөр хятруун, Тарагт сумын Хүрэмт, Эмт, Арвайхээр сумын Дэлгэрэх, Бурхи зэрэг рашаануудын физик, химийн найрлагыг тодорхойлох судалгааны ажлыг 2022 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар МУ-ын усны чанарын зөвлөх инженер, гидрохимич Ч.Жавзан доктороор ахлуулсан судалгааны багаар гүйцэтгүүлж микробиологи, бичил элементийн 86 үзүүлэлтээр нарийн тодорхойлуулж, тайланг хүлээн авч ИТХ-д танилцуулсан. Судалгааны үр дүнд гарсан зөвлөмж, дүгнэлтүүдийг холбогдох сумдад хүргүүлж, бохирдолтой гарсан рашаануудыг буцалгаж унд ахуйдаа хэрэглэх талаар заавар зөвлөмжийг байгууллагын цахим

хэлбэрээр иргэд олон нийтэд сурталчилж, Дэлгэрэх, Бурхийн рашаан дээр анхааруулах самбар байршууллаа.

5. Өлзийт сумын Сангийн далай орчмын 6560 га талбайг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 04/05 дугаар тогтоолоор аймгийн тусгай хамгаалалтад авч, тухайн газарт мөрдөх дэглэмийг баталсан. Онги, Таац голын урсац бүрэлдэх эх бүхий Уянга, Нарийнтээл сумдын нутагт орших “Хангайн нуруу”-ны салбар уулсын үзүүр төгсгөл хэсэг, Баруунбаян-Улаан, Богд сумдын нутагт орших “Зүүн богд уул”-ын нийт 154.170 га тус тус байгалийн нөөц газрын ангиллаар Улсын тусгай хамгаалалтад авах тухай аймгийн Засаг даргын саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 14-ны өдрийн 18/03 дугаар тогтоолоор дэмжсэн. Тус тусгай хамгаалалтад авах санал уламжлах тухай тогтоолыг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлээд байна.

6. Орхон голоос эх авч Онги голын урсацыг нэмэгдүүлэн Улаан нуурыг тэтгэж, улмаар говийн бүсийн сум суурингийн хүн ам, бэлчээр, хөдөө аж ахуй, уул уурхайн үйлдвэрлэлийн ус хангамжийн найдвартай эх үүсвэр бий болгох, эрчим хүч үйлдвэрлэх зорилготой “Орхон-Онги” эко төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг 2021 онд боловсруулсан. Тус төслийн ТЭЗҮ-ийг “Хайдродизайн прожект” ХХК, “Престиж инженеринг” ХХК, “Монхидро констракшн” ХХК, “Жемр” ХХК-иуд хамтран гүйцэтгэсэн.

7. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй гэрээ байгуулан Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын багаар ахлуулсан ажлын хэсэг аймгийн 19 сумын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн худаг, ус түгээх байр, булаг, голын уснаас нийт 55 цэгээс 86 физик-хими, бичил элемент, бичил амь судлал, цацрагийн аюулгүй үзүүлэлтүүдийг тодорхойлуулан ундны усны чанарын судалгааны тайланг сумдын тоогоор хэвлүүлж, <https://www.wsrc.mn/new/mn/> сайтаас тухайн сум орон нутгийн ундны усны чанарын үзүүлэлтүүдийг харахад нээлттэй байдлаар байршуулсан. Хөдөө аж ахуйн болон бэлчээрийн ус хангамжийг сайжруулах ажлын хүрээнд улс орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хүрээнд сумд малын тоо толгойн албан татварын хөрөнгөөс нийт 335.5 төгрөгийн хөрөнгөөр худгийн 24 цооногийг шинээр гаргаж, энгийн уурхайн 36 худгийг засварлан нийт 54.0 мянган га бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлсэн байна.

8. Арвайхээр хотын гэр хорооллын айл өрхүүдийг сайжруулсан шахмал түлшээр хангах ажлын хүрээнд 2021 онд “Баянтээг түлш” ОНӨХХК-нь нийт 462 тонн шахмал түлш үйлдвэрлэж, Арвайхээр сумын Эмтийн 2-р багийн 300-400 айл өрхийн хэрэглээнд нэвтрүүлэн угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор 508 өрхөд угаар мэдрэгч төхөөрөмж суурилуулсан.

“Баянтээг түлш” ОНӨХХК-нь 2022 онд 380 тонн шахмал түлш үйлдвэрлэж, Арвайхээр сумын Эмтийн 2-р багийн гэр хорооллын 500 айл өрхүүдийг шахмал түлшээр ханган ажилласан ба Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос 2,0 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлж шахмал түлш нөөцлөх агуулахын барилга, үйлдвэрийн өргөтгөл, олон үйлдэлт зуух, хатаалтын төхөөрөмжийн угсралтын ажлуудыг эхлүүлсэн. Мөн тухайн хорооноос Арвайхээр суманд дамжуулагчтай 2000, дамжуулагчгүй 1000 нийт 3000 ширхэг угаар мэдрэгч төхөөрөмж хүлээлгэн өгч 2023 онд Арвайхээр сумын 1, 2, 3, 7, 9, 12 дугаар багийн 1500 орчим айлд угаар мэдрэгч суурилуулж, сайжруулсан шахмал түлшийг түлшиндээ хэрэглэж байна.

9. Азийн хөгжлийн банкны ядуурлыг бууруулах Япон сангийн төслөөр аймгийн “Хог хаягдлын менежментийг сайжруулах стратеги төлөвлөгөө”-г боловсруулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 09/09 дүгээр тогтоолоор батлуулсан. 2021-2023 онд аймгийн хэмжээнд 350 гаруй тн хог хаягдлыг ангилан ялгаж, 2-догч түүхий эд хүлээн авах цэгт нийлүүлэгдсэн байна. 2023 онд 399.65 тн хог хаягдал ангилан ялгаж дахин боловсруулах, сэргээн ашиглах, дахин ашигласан байна.

-2023 оны аймгийн хэмжээнд бүх нийтийг хамарсан их цэвэрлэгээг 5 удаа зохион байгуулж 1,088 тн хог хаягдлыг зөөн тээвэрлэж дарж булсан байна.



10. “Арвайхээр тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ нь 2021 онд хаягдал хуванцар дахин боловсруулах үйлдвэр барьж хатуу хуванцарыг хайлуулан хашааны шон, замын хашлага, бохирын кальцо зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан модны хашаа, хашлаганд шаардагдах хашааны шон нийлүүлэхээр Байгаль орчин, аялал жуулчлалын газартай гэрээ байгуулж нийт 36 тонн хуванцраар 3600 ширхэг шон хийж хүлээлгэн өгсөн. Уг арга хэмжээнд байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 18,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Мөн орон нутгийн төсвийн 15,0 сая төгрөгөөр нягтруулах пресслэгч төхөөрөмж, тус бүр 9,0 сая төгрөгийн үнэ бүхий ангилан ялгах 2 ш хогийн сав нийлүүлж дэмжлэг үзүүлсэн.

-Арвайхээр тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ аймгийн төвүүдийн хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах МОН-9206 төслийн хүрээнд 45,0 сая төгрөгийн санхүүжилт авч хүчин чадал сайтай хуванцар бутлагч машин авч ашиглалтад оруулан 2022 онд хог хаягдлыг ангилан ялгах, хуванцарыг дахин боловсруулах зорилгоор 29,9 тн хуванцрыг буталж нийт 2985 ширхэг хашааны шон хийсэн.

Аймгийн хэмжээнд дахивар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх ажлын хүрээнд 14 суманд хоёрдогч түүхий эд хүлээн авах 28 цэг байгуулагдаж, 301,8 тн дахивар хаягдлыг цуглуулан аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг “Эко цэнэ”, “Цэмцгэр” төвүүд болон Улаанбаатар хот руу нийлүүлээд байна.



Аймгийн хэмжээнд 14 сум хоёрдогч түүхий эд пресслэх 21 төхөөрөмжтэй болж лус, орон нутаг, төсөл хөтөлбөрийн 78,5 сая төгрөг зарцуулагдсан байна.

11. “Эко жорлон” арга хэмжээний хүрээнд Азийн хөгжийн банк болон орон нутгийн төсвийн 480.0 сая төгрөгийн санхүүжилтээр 2019-2021 онд “КА-9100-МОН” төсөлд Арвайхээр сумын 13 багийн 283 өрх тус төсөлд хамрагдаж сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болсон. Аймгийн хэмжээнд нийт 29 жуулчны бааз сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болж, Орхоны Хөндийн байгалийн цогцолборт газрын Найман нуур, Ширээт нуурын эрэгт байгуулагдсан отоглох цэгүүдэд 4 ш сайжруулсан ариун цэврийн байгууламж байгуулсан.

-2021 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар усны сан бүхий газрын хамгаалалтын бүс болох Онги, Дайргын голын орчимд хөрсөнд үл нэвчих 3 ш ариун цэврийн байгууламж, хог хуримтлуулах бункерийг байгуулж, ашиглалтад оруулсан.

-2022 онд аялал жуулчлалын эвент арга хэмжээнд зориулж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 38,0 сая төгрөгөөр 17 суултуур бүхий 3 ш зөөврийн эко ариун цэврийн байгууламжтай болсон. 2022-2023 онд хөрс бохирдуулагч жорлонгийн тоог үе

шаттайгаар бууруулах ажлын хүрээнд стандартын шаардлага хангаагүй 24 нүхэн жорлонг буулган дарж тухайн газрыг ариутгах ажлыг зохион байгуулсан.

12. Аймгийн байгалийн ургамлын тархац, нөөцийн судалгааны ажлыг 2021 онд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар Шинжлэх ухааны академийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгээр гүйцэтгүүлж тайланг хүлээн авсан. Судалгааны үр дүнд 61 овгийн 238 төрлийн 517 зүйл ургамал бүртгэгдэж, нэн ховор ургамлын 12 овгийн 13 зүйл ургамлын 48 тархцын цэг, ховор ургамлын 17 овгийн 31 зүйл ургамал, эмийн болон хүнсний ашиглалтад өртөж буй 111 зүйл ургамлын 1059 тархцын цэгийг тогтоосон. 2021-2023 онд нэн ховор, ховор амьтдад болох аргаль, янгир, халиун буга, бор гөрөөс зэрэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах ажлыг зохион байгуулж, нийт 15 сумын 133 цэгт 4150 боодол өвс, 10.8 тонн хужир тавьж өгөх ажлыг холбогдох сумдын ЗДТГ, БОХУБ, Байгаль хамгаалагч, ТББ-ууд, нөхөрлөлийн гишүүдтэй хамтран хийж гүйцэтгэсэн.

Өвөрхангай аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгаа, 2024-2028 онд хэрэгжүүлэх ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг мэргэжлийн байгууллага “Авралын эрэлд” ХХК-иар хийлгүүлж, ерөнхий агнуур зохион байгуулалтын судалгааны тайлан, аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөний төслийг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлээд байна.

13. Аймгийн хэмжээнд 2021-2023 онд ашигт малтмал олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон 349,75 га газарт техникийн, 65,9 га газарт биологийн нөхөн сэргээлтийн ажлыг үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжүүдээр холбогдох стандартын дагуу хийлгэж, талбайг актаар хүлээн авч ажилласан.



Дээрх аж ахуйн нэгжүүд нь хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэсэн бөгөөд хуулийн хариуцлага тооцогдсон аж ахуйн нэгж байхгүй болно.

14. Байгаль орчны хууль тогтоомж, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсролыг олон нийтэд сурталчлан таниулж, стандарт, хэм хэмжээг мөрдүүлэн, байгаль хамгаалалд иргэдийн оролцоог

нэмэгдүүлэх зорилгоор 2021-2023 онд орон нутгийн “Соёмбо” болон МҮОНР телевиз, ӨВ live.mn сайт, эх бэлтгэлийн “Оюунана брэнд” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, 156 эх бэлтгэл, сурталчилгааны фостер, 55 удаагийн мэдээ, 15 сэдвийн сурвалжилга, 10 шторк, шууд live нэвтрүүлгүүдийг хийлгэж байгууллагын цахим хуудас болон сайтаар иргэд олон нийтэд хүргэж, иргэд, өсвөр үеийнхэнд 25 удаагийн сургалт, 2 удаагийн чуулган зохион байгууллаа.

14. Байгаль орчны салбарын хүний нөөцийг чадавхжуулах, нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцлийг сайжруулах хүрээнд албан хаагчдыг чадавхжуулах дотоод сургалтыг жилд 2-с доошгүй удаа зохион байгуулж, 2021 онд тус газрын харьяа сумдын байгаль хамгаалагч нарын өвлийн хувцсыг шинэчилж, 2023 онд бүх мэргэжилтнүүдийг ажлын хувцасаар хангаж 5 мэргэжилтний компьютер, техник хэрэгслэлийг шинэчилж эдгээр арга хэмжээнд 28,0 сая төгрөг зарцуулсан.

15. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Мод үржүүлгийн мэргэжлийн байгууллагуудыг бодлогоор дэмжиж 2021 онд Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газар болон “Арвайхээр-Цэцэрлэгжилт” ОНӨААТҮГ-ын мод үржүүлгийн газруудын өргөтгөл тарьц суулгац худалдан авахад зориулж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 24,0 сая төгрөг, 2022 онд аймгийн нутаг дэвсгэрт мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор хангай, тал хээр, говиор бүсчилж 5 аж ахуйн нэгж, байгууллагад 216,0 сая төгрөг, 2023 онд Сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газарт шаардлагатай үр, мөчир бэлтгэх, бордоо, ариутгалын бодис, хүлэмж, услалтын систем авах, гэрээт ажилтан ажиллуулах зэрэг ажилд дэмжлэг үзүүлж Бат-Өлзий сумын орон нутгийн төсөв, БОХНСАХэмжээний зардлаас 30,0 сая төгрөг нийт 270,0 сая төгрөгийн санхүүжилт тус тус олголоо.

-Улсын хэмжээнд 2023 онд явагдсан мод үржүүлгийн газруудын бүртгэл тооллогоор тус аймгийн Арвайхээр, Тарагт, Зүүнбаян-Улаан, Баруунбаян-Улаан, Хужирт, Хархорин, Бат-Өлзий сумдад мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхэлдэг 19 аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хамрагдаж нийт 20 гаруй нэр төрлийн 5.7 сая орчим тарьц суулгац байгаагаас ирэх онд ойжуулалт, цэцэрлэгжүүлэлтэд шилжүүлэх боломжтой 2-с дээш настай 1.2 сая тарьц суулгац тоологдлоо.

16. Ойн тэлэн ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, унанги мод цэвэрлэх, ой хамгааллын арга хэмжээний хүрээнд 2021-2023 онд ой цэвэрлэгээний журмаар мод бэлтгэх ажлыг хавар, намар тогтмол зохион байгуулж, 697 га талбайд ой цэвэрлэгээний ажил хийгдэж, хэрэглээний мод 12057 шоометр, түлээний мод 63188, нийт 75245 шоо метр мод бэлтгэж ойгоос мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлого болон байгалийн дагалт баялаг ашигласны төлбөр нийт 1,5 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Ой цэвэрлэгээгээр мод бэлтгэх ажилд жил бүр 20 гаруй аж ахуйн нэгж, нөхөрлөл оролцож байна.

Ойн хомсдлоос сэргийлэх зорилгоор ойн хөнөөлт шавжийн устгал тэмцлийн ажил 2021-2023 онд 39650 га талбайд хийгдэж улс, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр 1,5 тэрбум орчим төгрөг зарцуулсан байна.

17. Аймгийн хэмжээгээр төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээ 2020 оны суурь түвшингээс 85 га-р нэмэгдэж нийт 216,8 га болж нэмэгдсэн бөгөөд Арвайхээр сумын ногоон байгууламж 45 га талбайгаар нэмэгдлээ.



Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг улс, орон нутгийн төсөв, айл өрх, албан байгууллага, хувийн хэвшлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бөгөөд 2021-2023 онд сумдын орон нутгийн хөгжлийн сангаас 1,2 тэр бум төгрөг, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал болон орон нутгийн төсвөөс 1,7 тэрбум төгрөг, хувийн хөрөнгөөр 180,0 сая төгрөг нийт 3,1 тэрбум төгрөг зарцуулсан байна. Арвайхээр суманд 2022 онд 12 га цэцэрлэгт хүрээлэн, төв авто замын дагуу 1.5 км урт ойн зурвас, 2023 онд “Баян намсрай” 23 га цэцэрлэгт

хүрээлэн шинээр байгуулагдлаа.

18. Аймгийн аялал жуулчлалын бүс нутагт байгаль түүх соёлын өвд түшиглэн аялал жуулчлалын 5 эвент арга хэмжээнүүдийг тогтоосон хугацаанд зохион байгуулж ажиллалаа. Үүнд “Торгоны зам-Хархорум хот” соёл, аялал жуулчлалын фестиваль, Хужирт суманд “Монгол эсгий урлалын баяр”, Бат-Өлзий суманд “Сарлагийн баяр, Тэмээний баяр, KHARAKHURUM ICE FESTIVAL-2021” мөсөнд авиралтын цомын аварга шалгаруулах тэмцээнийг тогтсон хугацаанд зохион байгуулж 2021-2023 онд давхардсан тоогоор 3000 гаруй жуулчид ирж сонирхсон байна. Аймгийн аялал жуулчлалын цахим мэдээллийн сан бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах гар утасны аппликейшныг 2021 онд ашиглалтад оруулж, “Ай Ти Эм” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд 2021, 2022, 2023 онуудад давхардсан тоогоор 80 гаруй аж ахуйн нэгж нэгдсэн зохион байгуулалттайгаар оролцсон.

19. Төвхөн хийдийн угтах орчныг сайжруулах ажлын хүрээнд Германы сэргээн босголтын банкны KFW төслийн санхүүжилтээр мэдээллийн самбар, ширээ сандал, хогийн сав тус бүр 3 ш соруулдаг ариун цэврийн байгууламж байршуулж, аялагчдын тав тухтай аялах нөхцлийг сайжруулсан.

20. Хархорин, Эрдэнэзуу музейг холбосон аялал жуулчлалын гудамж байгуулах 4 багц ажил хийгдэж байна. Одоогийн байдлаар “Цэвэр ус, ариутгах татуургын шугам сүлжээ, бохирын цооног” хийх багц ажлын хүрээнд 520 метр цэвэр усны шугам, 480 метр бохир усны шугам татах ажил, “Гадна цахилгаан хангамж, гэрэлтүүлэг” багц ажлаас 1500 метр агаарын шугам татаж, 04 кв дэд станцыг байршуулах, “Явган зам, гадна хайс, сүүдрэвч” багцын хүрээнд 1100 метр хайсан хашаа, явган замын газар шорооны ажил тус тус хийгдээд байна. “Авто

зогсоол, эко хавтан” багц ажлын хүрээнд 28700 м2 хатуу хучилттай авто зогсоол, 3580 м2 эко хавтан зам баригдлаа.

21. “Дэлхийн өв” соёлын дурсгалт газрын хамгаалалтын захиргаа төсөл хэрэгжүүлж, эзэнт гүрний нийслэл Хархорум хотын туурийг хамгаалах хашааг барих ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, орон нутгийн төсвөөс 70.0 сая төгрөгөөр хашаажуулах ажлыг хийсэн. Монгол-Германы хамтарсан судалгааны баг 2023 оны 8 сарын 19-нөөс 9 сарын 19-ныг хүртэлх хугацаанд Хархорин хотын хэрмийн хойно орших XIII зууны Исламын шашны оршин суугчдын оршуулгын дурсгал газарт археологийн малтлага судалгааны ажил хийгдсэн.

22. Өндөр Гэгээн Занабазарын үйл хэргийг мөнхжүүлэх цогцолбор төвийг байгуулах арга хэмжээний хүрээнд Есөнзүйл сумын Засаг даргын Тамгын газраас “Өндөр гэгээн Занабазарын түүхэн мөрөөр” аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг боловсруулан орон нутгийн төсвийн 20.0 сая төгрөгөөр Өвгөн суврага орчимд жуулчид хоноглох 2 шовгор, хашаа барьж тохижилтын ажлууд хийгдсэн. Мөн иргэдийн хандив тусламжаар сэргээгдэх эрчим хүчээр цахилгааны асуудлыг шийдвэрлэж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Улсын төсвийн 2.4 тэрбум өртөг бүхий Өндөр Гэгээн Занабазарын музейг байгуулахаар 2024 оны төсөвт тусгасан бөгөөд одоогоор ажлын гүйцэтгэл 70 хувьтай хэрэгжиж байна.

23. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан аялал жуулчлалын зочлох үйлчилгээний цахим сургалтад тус аймгаас жуулчны бааз, зочид буудлын менежер, удирдлагын сургалтад 15, хөтчийн сургалтад 12, зочин хүлээн авагч, зөөгчийн сургалтад 8 иргэн, “Horeca” сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан аялал “Ковидын дараах сэргээн босголт” сэдэвт сургалтад Хархорин, Бат-Өлзий, Хужирт, Уянга, Арвайхээр сумдын нийт 50 гаруй аж ахуйн нэгж, төрийн байгуулагуудын төлөөллүүд тус тус хамрагдсан.



-Аймгийн Политехникийн коллежтой хамтран 2022-2023 оны хичээлийн жилд аяллын хөтөч, зочид буудлын үйлчилгээний

ажилтны ангид аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа орон нутгийн 50 иргэнийг суралцуулах ажлыг зохион байгуулж, 36 иргэнд мэргэжлийн үнэмлэхтэй олгосон.

24. Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор 2021-2022 онуудад “Өвөрхангайд үйлдвэрлэв”, “Хужиртад үйлдвэрлэв”, “Хархоринд үйлдвэрлэв” төвүүд ашиглалтад орж, орон нутгийн үйлдвэрлэгчдийн 600 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдан борлуулж байна.

25. Аялал жуулчлалын гол маршрутын дагуу Хархорин сум Орхон гол, Бат-Өлзий сумын Улаан цутгалан, Төвхөн хийд орчимд, мөн Бат-Өлзий сумын Хойд агуйт, Уянга сумын Хүйсийн найман нуур орчимд нийт 5 байршилд отоглох цэгүүдийг шинээр байгуулж, 2023 онд хувийн хэвшлийн хөрөнгө зэрэг үйлчилгээний 2 цогцолбор шинээр байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байна.

26. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 37 дугаар тогтоолоор “Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэд баримтлах журам”-ыг шинэчлэн баталсан. Журмын хэрэгжилтийн хүрээнд 2023 оны байдлаар 80 гаруй малчин өрх дотоод, гадаадын жуулчдад зориулан зочны гэр ажиллуулж, ердийн хөсөг болон бусад дагалдах үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

27. Аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, аяллын батлагдсан маршрутын танилцуулга бүхий Uvurhangaitravel гар утасны аппликейшныг ашиглалтад оруулж, иргэд олон нийтэд аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилж, аймгийн аялал жуулчлалын зөвлөгөөнийг жил бүр тогтмол зохион байгуулж байна.

28. Байгаль, түүх, соёл, мал аж ахуй, танин мэдэхүйн чиглэлээр орон нутгийн аялал жуулчлалын сүлжээ бий болгох зорилгоор, Соёлын өв Хөгжлийн дархлаа” цахим хуудсанд Төгрөг сумын соёлын төв “Ингэ хөөслүүлэх зан үйл”, Бат-Өлзий сумын соёлын төв

“Г.Занабазарын бүтээл”, Хайрхандулаан сумын соёлын төв “Суран эдлэл”-ийн өв соёлын контентыг бэлтгэн байршуулсан.

-Аймгийн түүхт 90 жилийн ойг тохиолдуулан хүүхэд багачуудад зориулан гаргасан “Миний Өвөрхангай” танин мэдэхүйн номд ан амьтан, байгалийн ургамал, ус, ой, уул уурхай, аялал жуулчлалын талаарх мэдээллүүдийг бэлтгэж оруулан иргэдийн гарт хүргэсэн.

29. “Аялал жуулчлалын тухай хууль” 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр шинэчлэгдэн батлагдаж, тус хуульд улс, орон нутгийн аялал жуулчлалын бүс тогтооно гэж заасны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 сарын 30-ны өдрийн хурлаар аймгийн аялал жуулчлалын бүсийг тогтоосон.

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ногоон хөгжил, аялал жуулчлалын талаар нийт 29 зорилт арга хэмжээ тусгагдсан бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар 94,4 хувьтай хэрэгжсэн байна.

ХЯНАСАН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА

Г.БАЯСГАЛАН

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД
АЖИЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Э.ЗОЛЗАЯА